



**ЭМЭЭЛТИЙН ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН  
ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ПАРК ОНӨТҮГ  
ДАРГЫН ТУШААЛ**

2016 оны 05 сарын 11 өдөр

Дугаар A/39

Улаанбаатар хот

Эд хөрөнгийн тооллогыг  
зохион байгуулах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 70 дугаар зүйл, Нийслэлийн Засаг даргын 2016 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн “Нийслэл, дүүргийн өмчийн эд хөрөнгийн үзлэг, тооллогын ажлыг зохион байгуулах тухай” А/298 дугаар захирамж, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 149 дүгээр тогтоолын хавсралт “Эмээлтийн хөнгөн үйлдвэрийн үйлдвэрлэл, технологийн парк” орон нутгийн өмчит төсөвт үйлдвэрийн газрын дүрэм”-ийн 5.1.8 дах заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Эд хөрөнгө тооллогын комиссыг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Тооллогын комиссын дарга

Мэдээллийн технологийн инженер, цахим архивч

Г.Цэнджав

Комиссын гишүүн

Дотоод хяналт-шинжилгээ, үнэлгээ  
хариуцсан мэргэжилтэн

А.Нямхүү

Нарийн бичгийн дарга

Архивын эрхлэгч

А.Анхзаяа

2. Сангийн сайдын 2016 оны 126 дугаар тушаалаар батлагдсан Төрийн болон орон нутгийн өмчийн тооллого явуулах журам, Төрийн болон орон нутгийн өмчийн тооллогын маягтыг ашиглах зааврын дагуу 2015 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн тайлангийн дүнгээр тасалбар болгон 2016 оны 05 дугаар сарын 17-ны өдрийн дотор тооллогыг зохион байгуулахыг Тооллогын комиссын дарга Г.Цэнджавт үүрэг бологосугай.

3. Тушаалын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Ерөнхий инженер бөгөөд барилгын инженер Г.Пүрэвдоржид даалгасугай.

ДАРГА



М.ГОНЧИГЖАВ

3150600039